




**Bers ABS  
plus**

# “БЭРС ЭЙ БИ ЭС ПЛАС ТЗК” ХХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юу Эй Эф Ассет Менежмент" ХХК (Хөрөнгө итгэмжлэн  
удирдагч)  
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот  
Утас: +976-70122346

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Гүйцэтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Б.Болор-Эрдэнэ /"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн ТУЗ-  
ийн дарга/



## **Агуулга**

---

1. ХБҮЦ-ны мэдээлэл .....	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл .....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл .....	5

## 1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 2 гишүүн, хараат 1 гишүүн, нийт 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Б.Болор-Эрдэнэ, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Д.Ганхүрэл, ТУЗ-ийн хараат гишүүнээр С.Отгонбат нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК ажиллаж байна.

"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК нь 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр 9.0 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

### Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Бэрс Эй Би Эс Плас ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011845634
Регистрийн дугаар	6949886
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2023/03/31
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	88
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	90,000
ХБҮЦ-ны үлдэгдэл (сая төг.)	9,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	19.2%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2023 онд ХБҮЦ-ны хүүгийн төлбөрт 866.37 сая төгрөгийг хуваарийн дагуу төлсөн байна. ХБҮЦ-ны үлдэгдэл хугацаанд Хүснэгт 2-т харуулсан төлбөрийг төлнө.

### Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо*	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр	Үлдэгдэл
1	2024/01/28	-	435,550,684.93	9,000,000,000.00
2	2024/04/28	4,500,000,000.00	430,816,438.36	4,500,000,000.00
3	2024/07/28	-	215,408,219.18	4,500,000,000.00
4	2024/10/28	-	217,775,342.47	4,500,000,000.00
5	2025/01/28	-	217,775,342.47	4,500,000,000.00
6	2025/04/28	4,500,000,000.00	213,041,095.89	-
	Нийт	9,000,000,000.00	1,730,367,123.30	



## 2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 1.47 хувиар буурсан байна.

### Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2023.04.28	2023.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	9,025,476,526.69	8,892,899,844.11	-1.47%
Зээлийн дундаж үлдэгдэл	6,646,153.55	9,551,986.94	43.72%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	0.44%	0.60%	0.16%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	3.95%	5.65%	1.70%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	40.20%	41.53%	1.33%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	47.31%	46.10%	-1.21%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	7.70	9.09	18.05%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	32.46	35.25	8.58%
Сарын дундаж төлбөрийн дүн	486,147.59	688,181.87	41.56%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	3,511,385.47	5,267,868.03	50.02%
Зээлийн тоо	1358	931	-31.44%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	0.00%
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	0.00%
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	24,733,445,500.00	23,435,140,790.00	-5.25%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.22%	0.22%
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс: (өсөн нэмэгдсэн дүнгээр)	-	9,663,375,122.42*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	7,625,157,079.39	-
Хүүгийн төлбөр	-	2,034,264,102.69	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	3,953,940.34	-

\*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2023 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 1.04 тэрбум төгрөгийг гэрээний дагуу 2024 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг ХБҮЦ-ны хүүгийн төлбөрийг төлөх хугацаатай уялдуулан арилжааны банкуудад хадгаламж хэлбэрээр байршуулж ажилласан бөгөөд 2023 оны эцсийн байдлаар ТЗК-ийн хадгаламжийн үлдэгдэл 0.0 төгрөг, харилцах дансны үлдэгдэл 10.94 сая төгрөг байна

Тайлант хугацаанд “Юү Эй Эф Ассет Менежмент” ХХК нь “Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

### Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	904	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	29	173,593,864.47
3	Багцад нэмж бүртгэсэн	506	7,714,070,596.06
Нийт		1,439	7,887,664,460.53



### 3. Төлөөлөн удирдах зөвлөл

“Бэрс Эй Би Эс Плас ТЗК” ХХК-ийг “Бэрс Финанс ББСБ” ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч “Бэрс Финанс ББСБ” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч”) байна.

2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 22/24а/02 тоот шийдвэрээр ТУЗ-ийн гишүүнээр С.Отгонбат, Б.Болор-Эрдэнэ болон Д.Ганхүрэл нарыг тус сонгож 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар хараат бус гишүүн Б.Болор-Эрдэнийг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 8 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

#### Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2023.02.09	1. ХБҮЦ гаргах тухай 2. Сонирхлын зөрчилтэй болон хэмжээний хэлцэл 3. Оролцогч талуудтай байгуулах гэрээний төсөл 4. Журам батлах тухай	1. Нийтэд нээлттэй арилжаалах 10 тэрбум төгрөгийн ХБҮЦ ерөнхий нөхцөлийг батлав. 2. ХБҮЦ гаргахтай холбоотой анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулах сонирхлын зөрчилтэй болон хэмжээний хэлцлийг батлав. 3. Оролцогч талуудтай байгуулах гэрээг батлав. 4. Үйл ажиллагаанд дагаж мөрдөх 7 журмыг тус тус батлав.
2	2023.03.30	Данс нээлгэх захиран зарцуулах эрх бүхий этгээд томилох тухай	Андеррайтераар дамжуулан Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн Төв ХХК-д данс нээлгэв.
3	2023.06.19	Үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай	Компанийн 2 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг төсвийг батлав.
4	2023.07.07	Санхүүгийн болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан баталгаажуулах тухай	2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
5	2023.09.18	Үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай	Компанийн 3 дугаар улирлын үйл ажиллагааны зардлыг төсвийг батлав.
6	2023.10.10	Санхүүгийн болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайлан баталгаажуулах тухай	2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагааны тайлан болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тайланг тус тус баталж СЗХ, МХБ болон хөрөнгө оруулагч нарт хүргүүлсэн.
7	2023.10.25	Хадгаламжийн данс нээх болон гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан томилох тухай	Капитрон банкинд хадгаламжийн данс нээж, дансны захиран зарцуулах эрхийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид олгов.
8	2023.12.26	Үйл ажиллагааны зардлын төсөв батлах тухай	Компанийн 4 дүгээр улирлын үйл ажиллагааны зардлыг төсвийг батлав.